



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 8/200

Жавхлант

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 дахь заалт, засгийн газрын "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" 110 дугаар тогтоолын 2.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 40 дүгээр тушаалаар баталсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхзаяа

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

М.Энхжин

Газрын даамал

Гишүүдэд:

Ш.Эрдэнэзаяа

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Х.Энх-Уянга

Дэлгэрхаан багийн Засаг дарга

Ж.Төртогтох

Наран багийн Засаг дарга

Г.Хүрэлбаатар

Сүмбэр багийн Засаг дарга

Н.Отгонбат

Байгаль хамгаалагч

2.Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах бүх ангиллын газрыг систем ашиглан аж ахуй нэгж, байгууллагаас санал авч багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, холбогдох газарт хүргүүлж ажиллахыг газрын даамал (М.Энхжин)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ЦОЛМОНБАЯР



D:Zasag darga /zahiramj-2025/